



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 03 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар ХЭГ/625

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Н.АМАРЗАЯА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Хуурамч, чанарын шаардлага хангахгүй шатахуунаар хэрэглэгчдэд үйлчилж байгаа асуудлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 5 хуудастай

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



~~Л.ОЮУН-ЭРДЭНЭ~~

0003124

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.АМАРЗАЯАГААС МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1. Керосин, нафта, хүнд, хөнгөн фракцын химийн нэрлэгийн бүтээгдэхүүнүүдэд онцгой албан татвар тогтоох шаардлагатай эсэхийг тодорхойлох

Хариулт. Манай улс газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэрэглээг 100% импортоор хангадаг бөгөөд 2018 онд 1,87 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос керосин 109,2 мянган тонн, газрын тосны хүнд фракцын нэгдэл 105,6 мянган тонн, хөнгөн нэрлэгийн фракц буюу нафта 18,2 мянган тонн, алкалит 26,9 мянган тонн, нийт 259,9 мянган тонн байгаа нь нийт импортолсон газрын тосны бүтээгдэхүүний 13.8 хувийг эзэлж байна.




Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ 2015 онд буурсантай холбоотойгоор ОХУ-ын “Роснефть” компаниас нийлүүлэх автобензин, дизель түлшний импортын үнэ буурсан зах зээлийн таатай үед буюу 2015 оны 11 дүгээр сараас Засгийн газраас автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг боомтуудаар импортолж буй автобензинд тонн тутамд 400,000 төгрөг, дизель түлшинд 520,000 төгрөг, Эрээнцав боомтоор импортолж буй автобензинд 270,000 төгрөг, дизель түлшинд 290,000 төгрөгт хүргэн тус тус нэмэгдүүлсэн.

Онцгой албан татвар нэмэгдсэн үеэс буюу 2016 оноос эхлэн онцгой албан татваргүй нефть-химийн бүтээгдэхүүний импорт нэмэгдсэн. Тодруулбал, 2015 онд нефть-химийн бүтээгдэхүүн нийт 21.7 мянган тонныг импортолсноос керосин 4.47 мянган тонн, газрын тосны хүнд фракцын нэгдэл 1.72 мянган тонн, хөнгөн нэрлэгийн фракц нафта 8.79 мянган тонн, алкалит 6.73 мянган тонн байсан бол 2016 онд

нефть-химийн бүтээгдэхүүн нийт 90.61 мянган тонн импортолсноос керосин 59.4 мянган тонн, газрын тосны хүнд фракцын нэгдэл 2.57 мянган тонн, хөнгөн нэрлэгийн фракц буюу нафта 20.79 мянган тонн, алкалит 7.84 мянган тонн болж тус тус өссөн ба өмнөх онтой харьцуулахад керосины импорт 13.2 дахин, нафта 2.3 дахин өссөн байна.

Хэдийгээр 2016 оны сүүлийн хагас жилээс эхлэн ам.доллартой харьцах төгрөгийн ханш суларсан, шатахууны импортын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор шатахууны үнэ өсөх нөхцөл үүссэн тул Засгийн газраас автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг 2016 оны 10 дугаар сараас 2017 оны 2 дугаар сарын хооронд 3 удаа бууруулсан, 2018 оны 01 дүгээр сараас А-80 болон А-92 автобензины онцгой албан татварыг тэглэсэн боловч нефть-химийн бүтээгдэхүүний импорт тасралтгүй өссөөр байгаа юм. Тухайлбал 2017 онд нефть-химийн бүтээгдэхүүн нийт 120.171 мянган тонн импортолсноос керосин 48.5 мянган тонн, газрын тосны хүнд фракцын нэгдэл 27.8 мянган тонн, хөнгөн нэрлэгийн фракц буюу нафта 27.89 мянган тонн, алкалит 15.92 мянган тонн байсан бол 2018 онд керосин 109.2 мянган тонн, газрын тосны хүнд фракцын нэгдэл 105.6 мянган тонн, хөнгөн нэрлэгийн фракц буюу нафта 18.2 мянган тонн, алкалит 26.9 мянган тонныг импортолж, нийт импортолсон газрын тосны бүтээгдэхүүний 13.8 хувийг эзэлж байна.

Нефть-химийн бүтээгдэхүүний импорт.



Эдгээр нефть-химийн бүтээгдэхүүний импорт бодит хэрэгцээнээс хэдэн арав дахин илүү байгаа нь Онцгой албан татваргүй тухайн бүтээгдэхүүнүүдийг хольж, найруулах замаар чанарын шаардлага хангахгүй шатахуун гарган авч, зах зээлд нийлүүлж байна гэж үзэж байна.

Иймд чанарын шаардлага хангахгүй автобензин, дизель түлш үйлдвэрлэх зориулалтаар импортолж буй нефть-химийн бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх замаар импортыг хязгаарлах зайлшгүй шаардлагатай байгаа ба энэ чиглэлээр өнгөрсөн 2 жилийн хугацаанд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн боловч одоогоор тодорхой үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал:

- Шатахууны онцгой албан татварын хэмжээг чанар, стандарттай уялдуулан тогтоох, чанарын шаардлага хангахгүй автобензин, дизель түлш үйлдвэрлэх зориулалтаар импортолж буй үндсэн /керосин, нафта зэрэг/ болон нэмэлт бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Онцгой албан татварын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байна.
- Онцгой албан татварын хэмжээг газрын тосны бүтээгдэхүүний төрөл, чанар, стандарт, импортолж буй боомттой уялдуулан тогтоох хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 10 дугаар сарын хурлаар хэлэлцүүлсэн ба ОББҮХ-ны 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 18/03-1 дугаар тогтоолоор тухайн асуудлаар хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох сайд нарт даалгасан.
- Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй автобензин, дизель түлшний борлуулалтыг хориглосон шийдвэр гаргах нь одоо мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж стандартуудтай зөрчилдөх нөхцөл байдал үүсэх тул агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Агаарын тухай хуульд нэмэлт оруулах асуудлыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 10 дугаар сарын хуралдаанаар хэлэлцүүлсэн ба ОББҮХ-ны 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 18/03-1 дугаар тогтоолоор Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох сайд нарт даалгасан.
- УИХ-ын ЭЗБХ-ны хуралд газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлыг танилцуулсан ба ЭЗБХ-ны 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 32 дугаар тогтоолоор "газрын тосны зарим төрлийн бэлэн болон завсрын бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах, экологийн ангилал, импортолж байгаа боомтоос хамааруулан автобензин, дизелийн түлшний албан татварыг ялгавартай тогтоох, шатахууны үнийн огцом хэлбэлзлийг онцгой албан татварын хувь хэмжээгээр тухай бүр шуурхай зохицуулах зэрэг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх"-ийг Засгийн газарт чиглэл болгосон.
- УИХ-ын ЭЗБХ-ны 32 дугаар тогтоол, ОББҮХ-ны 18/03-1 дугаар тогтоолын холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангах хүрээнд Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулж байна.

Мөн одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиудад зөвхөн бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр заасан ба харин эдгээр нефть-химийн бүтээгдэхүүнтэй холбоотой харилцааг зохицуулаагүй нь эдгээр нефть-химийн бүтээгдэхүүнийг импортлогч, борлуулагч аж ахуйн нэгжүүдэд дээрх хуулиудын дагуу хяналт шалгалт хийх, борлуулалт, зарцуулалтын тайланг гаргуулан авах, хариуцлага тооцох хууль, эрх зүйн боломжгүй байна.

Иймд цаашид Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний худалдааг

тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Чанарын шаардлага хангахгүй шатахуун гарган авах зориулалтаар импортолж буй нефть-химийн бүтээгдэхүүнд агуулагдах хар тугалга, төмөр, марганец зэрэг хүнд металлын агууламж өндөр байдаг ба энэ нь хүний эрүүл мэндэд ихээхэн аюултайгаас гадна хүрээлэн буй орчин, агаарын чанар, автотээврийн хэрэгслийн ашиглалтад сөргөөр нөлөөлөх ихээхэн хор уршигтай төдийгүй чанарын шаардлага хангахгүй шатахууны борлуулалт нэмэгдэх нь хэрэглэгчдийн эрх ашгийг ноцтойгоор зөрчиж буй үйлдэл юм.

Асуулга 2. Цаашид энэ төрлийн чанаргүй бензин үйлдвэрлэгч, түүнийг худалдан борлуулагч нартай хэрхэн ажиллах, хэрэглэгч нарын гомдлыг хэрхэн барагдуулах, ямар арга хэмжээ авах талаар

Хариулт. Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 201 дүгээр захирамжаар газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон газрын тосны бүтээгдэхүүний бөөний, жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тус захирамжийн дагуу Шадар сайдын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах дэд ажлын хэсэг байгуулагдсан ба 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдөр анхдугаар хурлаа хийж, ажлын хэсгийн хяналт, шалгалтын хамрах хүрээ, ажлын төлөвлөгөө гаргахад шаардлагатай холбогдох мэдээ, мэдээлэл гаргаж ирэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан байгууллага, гишүүдэд даалгасан.

Тус дэд ажлын хэсэг нь удирдамжид заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон газрын тосны бүтээгдэхүүний бөөний, жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийх, холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох асуудлыг судлах, санал, дүгнэлт гаргах, тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах үндсэн зорилготой.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 201 дүгээр захирамж, Шадар сайдын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн хүрээнд чанарын шаардлага хангахгүй шатахуунтай холбоотой асуудлыг шийдвэрлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох боломжтой гэж үзэж байна.

Мөн шатахууны Онцгой албан татварын хэмжээг чанар, стандарттай уялдуулан тогтоох, чанарын шаардлага хангахгүй автобензин, дизель түлш үйлдвэрлэх зориулалтаар импортолж буй үндсэн /керосин, нафта, газрын тосны хүнд фракцын нэгдэл, алкалит зэрэг/ болон нэмэлт бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад

нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай.

Асуулга 3. Дээрх бүтээгдэхүүнүүдийн хэтийн хэрэглээ, түүний тооцооллыг нарийвчлан гаргах, түүний хэрэглээнд хяналт тавих ямар боломж байгаа талаар

Хариулт. Өнөөгийн байдлаар керосиныг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй Ачит-Эхт ХХК, Эрдмин ХХК-иуд зэс уусган баяжуулах үйл ажиллагаанд бага хэмжээгээр ашигладаг. Тухайн компаниудын жилийн хэрэглээ 3000 орчим тонн бөгөөд мөн бага хэмжээний керосиныг зарим аж ахуйн нэгж халаалтад ашиглаж байна.

Харин бусад нефть-химийн бүтээгдэхүүнийг тухайн зориулалтаар ашиглаж байгаа тухай мэдээ, мэдээлэл байхгүй байна. Эдгээр нефть-химийн бүтээгдэхүүн нь газрын тос боловсруулах үйлдвэрийн анхан шатны нэрлэгээс гарсан хагас боловсруулсан завсрын бүтээгдэхүүн бөгөөд цаашид үйлдвэрийн нэрлэгийн аргаар дахин гүн боловсруулалт хийж эцсийн бүтээгдэхүүн гарган авдаг.

-----oOo-----